ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

# НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГО

| | |
|---|---|
| **Хамрах хүрээ:**<br>“Есөн шижир инвест ББСБ” ХХК-ийн<br>Нийт ажилтнууд | **Хариуцан ажиллах эзэн:**<br>Төлөөлөн удирдах зөвлөл<br>Ерөнхий аудитор |
| **Хувийг хадгалах:**<br>ТУЗ | **Танилцах:**<br>“Есөн шижир инвест ББСБ” ХХК-ийн<br>Нийт ажилтнууд |
| **Хүчинтэй хугацаа:**<br>2025 оны 12 сарын 26-ны өдрөөс эхлэн | **Хуудасны тоо:**<br>2 |
| **Бодлогын дугаар:**<br>25/01 | |

**Бодлогын түүх**

| **Хувилбар** | | **Өөрчлөлт хийгдсэн огноо** | **Өөрчлөлтийн агуулга** |
|---|---|---|---|
| 1. | Анх батлагдсан огноо | 2025.12.26 | Анх боловсруулсан |
| 2. | | | |
| 3. | | | |
| 4. | | | |
| 5. | | | |
| 6. | | | |

# НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГО

## Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү бодлого нь "Нэгдсэн менежментийн тогтолцоо /ISO 9001:2015, ISO 27001:2022/ олон улсын стандарт"-ын /цаашид "нэгдсэн менежментийн тогтолцоо" гэх / шаардлагуудыг хангуулах, түүнийг хэрэгжүүлэх, тогтмол сайжруулахад мөрдлөг болно.

Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогыг ББСБ-ын бүх салбар, газар нэгж болон холбогдох зохицуулагч байгууллагаас авсан тусгай зөвшөөрлийн дагуух бүх үйл ажиллагаанд хамааруулна.

Энэхүү бодлогыг нийтэд мэдээллэхдээ хураангуй байдлаар хүргүүлнэ.

## Хоёр. Зорилго, зорилт

### 2.1 Зорилго

Есөн шижир инвест ББСБ ХХК-ийн /цаашид "ББСБ" гэх/ нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогын зорилго нь ББСБ-ын эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөнд тулгуурлан харилцагчид болон бусад сонирхогч талуудын сэтгэл ханамжийг өндөр түвшинд байлгахыг эрхэмлэн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, үр дүнтэй удирдахад оршино.

### 2.2 Зорилт

Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогын зорилгыг хэрэгжүүлэхдээ дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1 Байгууллага (төлөв байдал): Стратеги, зорилтыг хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, зах зээл, өрсөлдөөн, эдийн засгийн нөхцөл байдал, нийгмийн чиг хандлагад тулгуурлан, хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.2.2 Манлайлал: Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал болон бүх удирдлагын түвшний ажилтнуудын манлайллыг бэхжүүлж, нэгдсэн менежментийн тогтолцооны талаарх мэдлэг, чадвар, уялдаа, хариуцлагыг байнга дээшлүүлж стратегийг дэмжих, чанарын бодлогыг хэрэгжүүлэх, шаардлагатай нөөцөөр хангах нөхцөлийг бүрэн бүрдүүлж ажиллана.

2.2.3 Төлөвлөлт: Байгууллага, харилцагч, түншүүд болон бусад сонирхогч талуудын үйл ажиллагаанд учирч болох эрсдэл болоод бий болох боломжийг богино хугацаанд тодорхойлж, үр нөлөөг хэмжинэ. Үүнийгээ бүх түвшний төлөвлөгөөтэй уялдуулан нийцүүлнэ.

2.2.4 Нөөц: Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогыг бүрэн бүрдүүлж хэрэгжүүлэхэд чиглэсэн ажилтан, санхүү, дэд бүтэц, технологи зэрэг шаардлагатай нөөцийг бүрэн тодорхойлж, бүхий л нөөцийн чадамжийг тогтмол сайжруулсан төлөвлөгөө хэрэгжүүлнэ.

2.2.5 Ажиллагаа: Тодорхойлсон бодлого, стратеги, зорилтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг гаргаж хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж, хөгжүүлэлтийг суурь зорилт болгон үйл явц бүрээр нарийн тодорхойлж гүйцэтгэнэ.

2.2.6 Гүйцэтгэлийн үнэлгээ: Үйл ажиллагаа, үйл явцуудын гүйцэтгэлийг хангахад шинжилгээ, үнэлгээний шинэлэг, дэвшилтэд аргачлалууд ашиглах ба шат дараалсан хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

2.2.7 Сайжруулалт: Харилцагчийн сэтгэл ханамж, ББСБ-ын үйл ажиллагаа, үр дүнд голлон чиглэх бөгөөд аливаа алдаа зөрчил, эрсдэл, үл тохирлоос урьдчилан сэргийлэх, тасралтгүй сайжруулах үйл явцуудыг бий болгоно.

2.2.8 Мэдээллийн аюулгүй байдал: Харилцагч, ажилтан, удирдлага, түншүүд болон бусад сонирхогч талуудын мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжид нөлөөлөх эрсдэлийг бүх түвшинд олон улсын стандартад нийцүүлэн тогтмол үнэлж, удирдан бууруулах зарчмаар ажиллана.

## Дөрөв. Хэрэгжүүлэх нэгж

4.1 Нэгдсэн менежментийн тогтолцоо -г нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа нь байгууллагын бүх шатны удирдлагын хамтын оролцоо, манлайлалд тулгуурлана.

ББСБ -ын нийт удирдлагууд нь дараах үүрэг, хариуцлагатай ажиллана.

4.1.1 Байгууллагын гүйцэтгэх захирал болон түүний дэргэдэх удирдлагын баг нь Нэгдсэн менежментийн тогтолцоо -г нэвтрүүлэх, үйл явцыг удирдан чиглүүлэх, дэмжих, хяналт тавих, нийт ажилтнуудыг сургах үүргийг хүлээнэ.

4.1.2 Нэгдсэн менежментийн тогтолцоо -г шаардлагуудыг бодлогын түвшинд стратегийн шийдвэр гаргах үйл ажиллагааны нэг хэсэг болгон авч үзнэ.

4.1.3 Нэгдсэн менежментийн тогтолцоо -г хэрэгжилтийн төлөвлөгөө, нөөцийн хуваарилалт, гүйцэтгэлийн үнэлгээг тогтмол хэлэлцэж, шаардлагатай сайжруулалтыг баталгаажуулна.

## Тав. Хэрэгжилтийг үр дүнг хянах

Нэгдсэн менежментийн тогтолцоо -ны шаардлагуудын дагуу байгууллагын дотоод дүрэм, журмуудыг боловсруулж, холбогдох удирдлагуудаар баталгаажуулна. Эдгээр дүрэм, журмын хүрээнд бодлогын хэрэгжилтийг тогтмол хянаж, үнэлж, дүгнэлт гарган сайжруулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

## Зургаа. Бусад

6.1 Энэхүү бодлогод нийцүүлж гаргасан холбогдох дүрэм, журмыг байгууллагын нийт ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлж ажиллана.

6.2 Ажилтнууд бодлогод нийцүүлж гаргасан холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллаагүйгээс үүдэж гарсан хохирлыг холбогдох хууль, тогтоомж, дотоод дүрэм, журам болон хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.3 Энэхүү бодлогыг жилдээ нэг удаа хянаж сайжруулна.

---oooOoo---